

2013 ОНЫ 5 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 6 дугаар сарын 13

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын салбартүйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид | /тоогоор/ | | | |
|---|--|------------|------------------|----------------|------------|
| | | 2013.05.01 | Нэмэгдсэн | Хасагдсан | 2013.05.31 |
| 1 | Даатгалын компани | 17 | | | 17 |
| 2 | Даатгалын компанийн салбар | 230 | 9 ¹ | | 239 |
| 3 | Даатгалын төлөөлөгч | 2698 | 331 ² | 6 ³ | 3023 |
| 4 | Даатгалын зуучлагч | 19 | 1 ⁴ | | 20 |
| 5 | Даатгалын хохирол үнэлэгч | 10 | 1 ⁵ | | 11 |
| 6 | Актуарч | 15 | | | 15 |
| 7 | Жолоочийн даатгалын зөвшөөрөл | 16 | | | 16 |
| 8 | Даатгалын зуучлагч компанийн салбар | | 12 ⁶ | | 12 |
| 9 | Даатгалын компанийн төлөөлөгчийн газар | | 4 ⁷ | | 4 |

¹Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 110 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 111 дүгээр тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Дархан-уул аймгийн Дархан сум, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 130 дугаар тушаалаар “Практикал даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Багануур, Налайх дүүрэг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 138 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн Ховд аймгийн Дөргөн сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутаг дэвсгэрт тус тус даатгалынүйл ажиллагаа эрхлэх салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөх шийдвэр гаргасан байна.

²Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 106 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 157 иргэнд, “Монгол даатгал” ХХК-ийн 115 иргэнд, “Номин даатгал” ХХК-ийн 6 иргэнд, “Моннис даатгал” ХХК-ийн 1 иргэнд, “Соёмбо даатгал” ХХК-ийн 4 иргэнд, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 108 дугаар тушаалаар “Мандал женерал даатгал” ХХК-ийн 3 иргэнд, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 137 дугаар тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн 20 иргэнд, “Монгол даатгал” ХХК-ийн 25 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

³Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 135 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 6 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

⁴Хорооны 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор “Эй Эс Ай Би” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

⁵Хорооны 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 187 дугаар тогтоолоор “Юу энд Эн” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгов.

⁶Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 107 дугаар тушаалаар “Хасбанк” ХХК-ийн 12 салбарт даатгалын зуучлагчийн салбарын тусгай шөврийг олгов.

⁷Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 109 дүгээр тушаалаар “Монгол даатгал” ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 120 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт тус тус даатгалын нөлөө лөгчийн газар ажиллуулах зөвшөөрлийг олгов.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 5 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Ердийн даатгалын компаниудын хувьд :

| Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|--|---------------------------|---------------------------|
| | 2013.05.31 /сарын дүн/ | 2013.05.31 /өссөн дүн/ |
| Даатгалын нийт хураамж | 8,472,651,152.74 | 29,091,990,285.23 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж | 2,741,178,047.22 | 5,946,376,669.76 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 2,065,209,257.22 | 10,621,945,174.91 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр | 751,839,949.30 | 4,274,763,310.10 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо | 1,950.00 | 9,518.00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 1,483,429,236.67 | 7,400,226,639.75 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 66,511.00 | 172,772.00 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо | 54,638.00 | 117,084.00 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо | 67,864.00 | 136,685.00 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 49,113,090,000.00 | 488,139,112,208.00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр | 98,560,000.00 | 256,077,546.49 |

2013 оны 5 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 29092.0 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 5946.4 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 10622.0 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 4274.7 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирол нөхөлтийн түвшин сарын байдлаар 24.3 хувь, өссөн дүнгээр 36.5 хувь болсон бөгөөд өмнөх сарын мөн үеийнхээс өссөн дүнгээр 5 пунктээр буурсан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

| Үзүүлэлт | 2013.05.31 /сарын дүн/ | /төгрөгөөр/ 2013.05.31 /өссөн дүн/ |
|---|---------------------------|--|
| Даатгалын нийт хураамж | 164,667,319.00 | 444,184,365.00 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 16,160,793.00 | 63,394,991.00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 26,756,989.00 | 29,369,471.00 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 15.00 | 81.00 |
| Хувь х үний хугацаат даатгалд | 5.00 | 11.00 |
| Байгууллагын хугацаат даатгалд | 2.00 | 8.00 |
| Өндөр хамгаалалттай ЭМД-д | 1.00 | 5.00 |
| Эмнэлгийн мөнгөний даатгалд | 1.00 | 15.00 |
| Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд | 3.00 | 13.00 |
| Тэтгэврийн даатгалд | | 15.00 |
| Орон сууцны даатгалд | | 2.00 |
| Хуримтлалын даатгалд | 1.00 | 4.00 |
| Зээлдэгчийн амь насны даатгалд | 2.00 | 13.00 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 1,400,000,000.0 | 3,000,000,000.0 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 2,854,970.00 | 11,229,913.00 |

Урт хугацааны даатгагч 2013 оны 5 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 444.2 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 63.4 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Өмнөх оны мөн үеийн 5 дугаар сарын дүнтэй харьцуулбал хураамжийн орлого 2.9 дахин, нөхөн төлбөр 2.4 дахин тус тус нэмэгджээ.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

| Үзүүлэлт | 2013.05.31 /сарын дүн/ | /төгрөгөөр/ 2013.05.31 /өссөн дүн/ |
|---|---------------------------|--|
| Нийт орлого | 54,019,189.78 | 146,267,228.63 |
| Даатгалын зуучлагчийн орлого | 28,001,012.81 | 119,089,746.71 |
| Үүнээс: Сайн дурын даатгал | 17,807,420.60 | 96,922,084.05 |
| Албан журмын даатгал | 3,978,712.65 | 10,472,336.70 |
| Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж | 48,374,760.13 | 186,503,516.36 |
| Зуучилсан даатгалын гэрээний тоо | 173.00 | 1,182.00 |

| | | |
|--|------------------|-------------------|
| Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ | 8,219,340,218.67 | 59,836,126,742.67 |
|--|------------------|-------------------|

2013 оны 5 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 119.1 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 81.3 хувийг сайн дурын даатгалаа өлдсөн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Лоялти солюшн” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Эм жи ай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмент” ХХК, ХХК, “Нэйшнл эженси” ХХК “Хасбанк” ХХК-иуд тус тус 5 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

| | /төгрөгөөр/ | |
|--|---------------------------|---------------------------|
| Үзүүлэлт | 2013.05.31 /сарын дүн/ | 2013.05.31 /өссөн дүн/ |
| Нийт орлого | 24,523,000.00 | 150,272,055.00 |
| Даатгалын хохирол үнэлгээний орлого | 15,652,091.00 | 54,677,099.00 |
| Үүнээс: Сайн дурын даатгал | 9,297,909.18 | 24,721,814.00 |
| Албан журмын даатгал | 6,354,181.82 | 29,955,284.00 |
| Үнэлсэн даатгалын хохирлын тоо | 871.00 | 4,331.00 |
| Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн | 13,491,000.00 | 45,598,724.00 |

2013 оны 5 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 54.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 45.1 хувийг сайн дурын, 54.9 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Жи эй си си” ХХК, “Мега марз” ХХК, “Гэрэгэ эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК-иуд тус тус 5 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 198 дугаар тогтоолоор “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг баталсан байна.

Хорооны 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах өвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг гаргасан байна.

Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 113 дугаар тушаалаар “Жомолхари” ХХК-д, 114 дүгээр тогтоолоор “Эм жи ай би” ХХК-д 115 дугаар тушаалаар “Асимон брокерс” ХХК-д, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 122 дугаар тушаалаар “Вендо” ХХК-д, 123 дугаар тушаалаар “Ренессанс групп” ХХК-д, 127 дугаар тушаалаар “Гэрэлт буян ундрах” ХХК-д, Хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 147 дугаар тушаалаар “Жи эй си си” ХХК-д тус тус дүрмийн сан /хувьцаа

эзэмшигчдийн хөрөнгө/-ийн бүтцэд өөрчлөлт оруулахыг эвшөөрсөн шийдвэрийг тус тус гаргасан байна.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС